

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2022/159/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p>	<p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Назгүл Утас: 99427301 Цахим хаяг: nazguld@ audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
3. Аудитын тайлан.....	15
3.1 Ерөнхий зүйл.....	15
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Материаллаг байдал	16
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	19
3.8 Аудитын гол асуудал	19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
4. Аудитын илрүүлэлт	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Төлбөрийн акт.....	20
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОБГ	Онцгой байдлын газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА
З.АЗАТ ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠘.᠐1 № 47
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймаг дахь Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймаг дахь Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн одог улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

ОБГ-dugnelt-2.01a

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *M. Хуанган* М.ХУАНГАН

ОБГ-dugnelt-2.01a

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			Төгрөгөөр
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,022,813,086.09	1006856261.89
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	
33	АВЛАГА	-	0.00
34	УРЬДЧИЛГАА	26,000,000.00	26000000.00
34600	Урьдчилж гарсан зардал	26,000,000.00	26000000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	996,813,086.09	980856261.89
351	Түүхий эд материал	672,356,435.34	687489422.64
35110	Тусгай зориулалттай материал	604,345,441.24	625053233.24
35130	Эм боох материал	68,010,994.10	62436189.40
35300	Бэлэн бүтээгдэхүүн	187,521,207.75	159158322.25
354	Хангамжийн материал	136,085,443.00	133358517.00
35410	Бичиг хэргийн материал	1,531,050.00	1550050.00
35420	Аж ахуйн материал	63,229,220.00	63229220.00
35430	Сэлбэг хэрэгсэл	17,351,563.00	6971563.00
35440	Түлш, шатах тослох материал	20,000,986.00	2655320.00
35460	Хүнсний материал	2,450,000.00	3122340.00
35470	Бусад хангамжийн материал	31,522,624.00	55830024.00
35600	Мал амьтад	850,000.00	850000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,957,644,353.65	6608232886.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,957,644,353.65	6608232886.54
392	Биет хөрөнгө	5,490,515,353.77	6141153886.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,722,621,201.03	4818741201.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,254,170,908.79)	1530269520.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,773,012,882.00	3853532882.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(810,335,857.98)	1048564002.84

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	993,704,255.42	984869814.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(960,587,010.02)	-965976626.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	22,198,358.00	26587100.73
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,085,899.45)	-13691961.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	119,324,039.20	108951130.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(103,165,705.64)	-93026129.92
393	Биет бус хөрөнгө	467,128,999.88	467078999.84
39301	Програм хангамж	2,250,000.00	250000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,150,000.12)	-200000.16
39303	Бусад биет бус хөрөнгө	467,029,000.00	467029000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>6,980,457,439.74</u>	<u>7615089148.43</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>6,980,457,439.74</u>	<u>7615089148.43</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	6,980,457,439.74	7615089148.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	794,950,269.92	794950269.92
51101	Өмч: - төрийн	794,950,269.92	794950269.92
512	Хуримтлагдсан үр дүн	2,323,578,920.65	2958451829.34
51210	Өмнөх үеийн үр дүн	1,620,695,249.44	2323820120.65
51220	Тайлант үеийн үр дүн	702,883,671.21	634631708.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,861,928,249.17	3861687049.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>6,980,457,439.74</u>	<u>7615089148.43</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,496,051,143.41	3,429,710,540.48
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,184,479,948.21	1,386,686,461.48

120	Нийтлэг татварын бус орлого	1,184,479,948.21	1,386,686,461.48
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,184,479,948.21	1,386,686,461.48
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,184,479,948.21	1,386,686,461.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,311,571,195.20	2,043,024,079.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,866,348,400.00	1,829,934,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,866,348,400.00	1,829,934,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	445,222,795.20	213,089,279.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	102,396,000.20	5,495,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,954,126.00	67,320,785.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	208,024,129.00	97,554,950.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	82,848,540.00	42,718,544.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,793,167,472.20	2,795,078,831.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,793,167,472.20	2,795,078,831.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,745,378,519.20	2,768,893,499.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,425,653,900.00	1,446,285,465.00
210101	Үндсэн цалин	919,648,000.00	834,230,865.00
210102	Нэмэгдэл	469,821,400.00	571,761,600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,184,500.00	40,293,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,335,200.00	44,566,303.00
210201	Тэтгэврийн даатгал	18,248,400.00	26,939,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,095,500.00	15,935,703.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,676,400.00	1,352,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,078,100.00	338,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,236,800.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,574,528.00	84,074,000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,875,500.00	11,006,300.00
210302	Түлш, халаалт	72,461,800.00	68,222,400.00

210303	Цэвэр, бохир ус	1,237,228.00	4,845,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,684,870.00	112,706,245.00
210401	Бичиг хэрэг	4,231,086.00	3,522,970.00
210402	Тээвэр, шатахуун	48,638,884.00	81,725,886.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,046,400.00	2,922,681.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	768,500.00	1,358,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		-
210408	Бараа материал акталсны зардал		23,176,208.00
2105	Нормативт зардал	374,543,078.90	260,797,458.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	227,160,873.90	28,234,854.70
210502	Хоол, хүнс	147,318,505.00	83,971,190.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	63,700.00	148,591,414.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,723,800.00	135,204,548.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,510,000.00	1,261,200.00
210604	Урсгал засвар	88,213,800.00	133,943,348.00
2107	Томилолт, зочны зардал	48,337,500.00	94,184,700.00
210702	Дотоод албан томилолт	48,337,500.00	94,184,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,231,790.00	16,453,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,745,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,932,400.00	3,932,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,105,690.00	683,300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	541,200.00	638,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,947,500.00	1,325,600.00
210807	Газрын төлбөр	3,129,000.00	3,129,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	597,293,852.30	574,621,079.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,366,283.20	37,240,950.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,842,800.00	4,408,980.00

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	485,084,769.10	532,971,149.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,788,953.00	26,185,332.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,600,000.00	4,767,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,600,000.00	4,767,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,188,953.00	21,418,232.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,188,953.00	21,418,232.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>702,883,671.21</u>	<u>634,631,708.69</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>702,883,671.21</u>	<u>634,631,708.69</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	1,620,695,249.44	6,277,573,768.53
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн			702,883,671.21	702,883,671.21
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,323,578,920.65	6,980,457,439.74
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,323,578,920.65	6,980,457,439.74
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			241,200.00	241,200.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	794,950,269.92	3,861,928,249.17	2,323,820,120.65	6,980,698,639.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-241,200.00		-241,200.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00

D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			634,631,708.69	634,631,708.69
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	794,950,269.92	3,861,687,049.17	2,958,451,829.34	7,615,089,148.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>2,311,571,195.20</u>	<u>2043024079.00</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,311,571,195.20	2043024079.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,866,348,400.00	1829934800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,866,348,400.00	1829934800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	445,222,795.20	213089279.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	102,396,000.20	5495000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	51,954,126.00	67320785.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	208,024,129.00	97554950.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	82,848,540.00	42718544.00
131106	Төсвийн урамшуулал		
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,311,571,195.20</u>	<u>2043024079.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,311,571,195.20	2043024079.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,263,782,242.20	2016838747.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,425,653,900.00	1446285465.00
210101	Үндсэн цалин	919,648,000.00	834230865.00
210102	Нэмэгдэл	469,821,400.00	571761600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,184,500.00	40293000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,335,200.00	44566303.00
210201	Тэтгэврийн даатгал	18,248,400.00	26939500.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,095,500.00	15935703.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	1,676,400.00	1352700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,078,100.00	338400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	29,236,800.00	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,695,028.00	85347000.00
210301	Гэрэл, цахилгаан	8,875,500.00	11006300.00
210302	Түлш, халаалт	60,582,300.00	69495400.00
210303	Цэвэр, бохир ус	1,237,228.00	4845300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,465,300.00	56781901.00
210401	Бичиг хэрэг	2,525,600.00	2998100.00
210402	Тээвэр, шатахуун	74,592,800.00	49348720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,846,900.00	2935081.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1500000.00
2105	Нормативт зардал	241,869,505.00	77420780.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	94,161,100.00	595800.00
210502	Хоол, хүнс	147,576,705.00	76824980.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	131,700.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	161,875,000.00	113730200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	76,650,900.00	15363100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	106,900.00	
210604	Урсгал засвар	85,117,200.00	98367100.00
2107	Томилолт, зочны зардал	48,337,500.00	94184700.00
210702	Дотоод албан томилолт	48,337,500.00	94184700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,350,090.00	19693700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6745400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	3,932,400.00	3932400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,105,690.00	683300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	541,200.00	638000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,065,800.00	4565600.00
210807	Газрын төлбөр	3,129,000.00	3129000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	165,200,719.20	78828698.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	162,686,519.20	72182398.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,514,200.00	6646300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,788,953.00	26185332.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,600,000.00	4767100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	40,600,000.00	4767100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,188,953.00	21418232.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,188,953.00	21418232.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	0.00
8	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1829934800.00	1808516568.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1829934800.00	1808516568.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1825167700.00	1803749468.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1460835900.00	1446285465.00
210101	Үндсэн цалин	848781300.00	834230865.00
210102	Нэмэгдэл	571761600.00	571761600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40293000.00	40293000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51434100.00	44566303.00
210201	Тэтгэврийн даатгал	26939500.00	26939500.00
210202	Тэтгэмжийн даатгал	22803500.00	15935703.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	1352700.00	1352700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	338400.00	338400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83966000.00	83966000.00
210301	Гэрэл, цахилгаан	11006300.00	11006300.00
210302	Түлш, халаалт	68114400.00	68114400.00
210303	Цэвэр, бохир ус	4845300.00	4845300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	41485000.00	41485000.00
210401	Бичиг хэрэг	2525600.00	2525600.00
210402	Тээвэр, шатахуун	35123100.00	35123100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2336300.00	2336300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1500000.00	1500000.00
2105	Нормативт зардал	55891800.00	55891800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	595800.00	595800.00
210502	Хоол, хүнс	55296000.00	55296000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	103730200.00	103730200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5363100.00	5363100.00
210604	Урсгал засвар	98367100.00	98367100.00
2107	Томилолт, зочны зардал	1484700.00	1484700.00
210702	Дотоод албан томилолт	1484700.00	1484700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19693700.00	19693700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6745400.00	6745400.00
210803	Даатгалын үйлчилгээ	3932400.00	3932400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	683300.00	683300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	638000.00	638000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4565600.00	4565600.00
210807	Газрын төлбөр	3129000.00	3129000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6646300.00	6646300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6646300.00	6646300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4767100.00	4767100.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4767100.00	4767100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4767100.00	4767100.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1829934800.00	1808516568.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1829934800.00	1808516568.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1829934800.00	1808516568.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	112.00	107.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00

620002	Гүйцэтгэх ажилтан	90.00	85.00
620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00
620004	Гэрээт ажилтан	4.00	4.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	0.00	0.00
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	0.00	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	112.0	107.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	91.00	86.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.00	17.00
650010	Гэрээт ажилтан	4.00	4.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	213089279.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	213089279.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	213089279.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1381000.00
210302	Түлш, халаалт	1381000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15296901.00
210401	Бичиг хэрэг	472500.00
210402	Тээвэр, шатахуун	14225620.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	598781.00
2105	Нормативт зардал	21528980.00
210502	Хоол, хүнс	21528980.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10000000.00
2107	Томилолт, зочны зардал	92700000.00
210702	Дотоод албан томилолт	92700000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72182398.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72182398.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	213089279.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	213089279.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5495000.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	67320785.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	97554950.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42718544.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хөрөнгө, бараа материалын бүртгэл тооцоотой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 19/31 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Тус газар нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, гамшгаас учирсан хор уршгийг арилгах, улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах, сэргээн босгох чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Онцгой байдлын газар нь 2021 онд “Хүн бүрийн сахилга, хариуцлага, мэдлэг чадварыг дээшлүүлснээр албаны техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэгсэлийн ашиглалтыг сайжруулах”, “Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, гамшгийн эрсдлийг бууруулах, түүнтэй тэмцэх үйл ажиллагаанд төрийн байгууллага болон иргэн, аж ахуйн нэгжийн уялдаа холбоог эрчимжүүлэх” 2 зорилт дэвшүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

ОБЕГ-ын дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар нь ОБЕГ, түүний харъяа төв орон нутгийн байгууллага салбар нэгжүүдэд хүрч ажилладаг. Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдалтай холбоотой хараат бус байдлыг бүрэн хэрэгжүүлж ажилладаг байна.

ОБЕГ-ын дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар нь харъяа айгууллагуудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж, тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хийж гүйцэтгэдэг байна.

Тус аймаг дахь Онцгой байдлын газарт 2021 онд дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2793.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 27.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Онцгой байдлын газрын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 702.9 сая төгрөгөөр буюу 11.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.00	0.00	0.00
Авлага	0.00	0.00	0.00
Урьдчилгаа	26,000.0	26,000.0	0.00

Бараа материал	996,813.1	980,856.3	-15,956.8
Үндсэн хөрөнгө	5,957,644.4	6,608,232.8	650,588.4
Нийт хөрөнгө	6,980,457.4	7,615,089.1	634,631.7
Өр төлбөр	0.00	0.00	0.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,980,457.4	7,615,089.1	634,631.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,980,457.4	7,615,089.1	634,631.7

Мөнгөн хөрөнгө, авлага дансууд оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна. Бараа материалын дансны үлдэгдэл 980.8 сая төгрөг болж 15.9 сая төгрөгөөр буурсан байна. Бараа материалын дансны бууралтыг судалж үзэхэд:

Тайлант онд 267.2 сая төгрөгийн бараа материал худалдан авч, төрийн болон орон нутгийн өмчит бус байгууллага, хувь хүнээс хандиваар 22.1 сая төгрөгийн бараа материал, салбар хооронд болон Онцгой байдлын ерөнхий газраас 181.1 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан байна.

Тайлант онд 463.1 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, тус газрын даргын тушаалаар ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй болсон 23.2 сая төгрөгийн бараа материалыг акталж данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,608.2 сая төгрөг болж 650.6 сая төгрөгөөр өссөн нь ОБЕГ-аас 2020 онд галын автомашин, фургон машин үнэ төлбөргүй авсан, Дэлүүн сумын эрэн хайх аврах бүлэг болон Цэнгэл сумын гал түймэр унтраах, аврах 71 дүгээр ангиудын байрыг орлогод авсантай холбоотой байна. Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,036.2 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Бусад биет бус хөрөнгө 8.3 сая төгрөгөөр өссөн шалтгаан нь Дэлүүн сумын эрэн хайх аврах бүлэг болон Цэнгэл сумын гал түймэр унтраах, аврах 71 дүгээр ангиудын эзэмшил газрыг орлогод авсантай холбоотой байна.

Өр төлбөр данс оны эхэн ба эцэст үлдэгдэлгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,615.1 сая төгрөг болж 634.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 634.6 сая төгрөг гарснаас шалтгаалжээ.

Онцгой байдлын газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 3,429.7 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 66.3 сая төгрөгөөр буюу 2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй орлого, урсгал санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна. Энэ нь хөрөнгийн санхүүжилтээр үндсэн хөрөнгө авсан, тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой тус газрын нэмэлт санхүүжилтийн дансаар иргэдийн тусгаарлах байр, хоолны зардлыг оруулж, холбогдох ААНБ-д шилжүүлж байсантай холбоотой нэмэлт санхүүжилтийн орлого материаллаг хэмжээний өөрчлөлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 1.9 сая төгрөгөөр буюу 0.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ-ийн зардал, хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар 0.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга гарсан нь тайлант онд бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй хөрөнгийг акталсантай холбоотой дахин үнэлгээний дүнг бууруулсантай холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны анх батлагдсан төсөв 1,790.3 сая төгрөг, тодотгосон төсөв 1,829.9 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 39.5 сая төгрөгөөр нэмэгджээ. Үүнд: цалингийн зардлыг 40.0 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 21.1 сая төгрөгөөр анх баталснаас бууруулж, байр ашиглахтай холбоотой зардлыг 0.4 сая, эд хогшил, урсгал засварын зардлыг 96.6 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 3.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгож анх баталснаас 39.5 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Шалтгаан нь: Тус байгууллага нь тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг, онцгой нөхцөл байдалд бэлэн байдлаа хангасан байх шаардлагатай байдаг тул ОБЕГ-т хандаж бэлэн байдлаа хангахтай холбоотой төсвөө тодотголоор нэмэгдүүлж батлуулсан байна. Үүнд:

ОБГ-ын цахилгааныг шинэчлэн татах, цахилгааны шугамд шинээр холбох, дулааны шугам, гараашийн талбайг хүнд даацын машинд тохируулж шинэчлэх, албан хаагчдын амрах байр барих, Толбо нуурын эрэг дээр уулын болон усны сургалтын байр барих, тээврийн хэрэгсэлүүдийг урсгал засварт оруулах зэрэг ажлыг хэрэгжүүлэх зориулалттай байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1,829.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1,808.5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг нийт дүнгээр 21.4 сая төгрөгөөр хэмнэж төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хэмнэлттэй гарсан зардлууд нь: цалингийн зардлыг 14.5 сая төгрөгөөр, НДШ-ийн зардлыг 6.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ нь 5 орон тоо сул байгаатай холбоотой хэмнэгдсэн байна. Сул орон гарч байгаа шалтгаан нь ажилтнууд өөр газарт шилжин ажиллахаар явах, тэтгэвэрт гарах зэрэг шалтгааны улмаас байнгын сул орон тоо гарч байсан байна. 2023 оноос орон тоогоо бүрэн нөхнө гэсэн тайлбайр өгч байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 5.5 сая, Засгийн газрын нөөц сан, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 67.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 97.5 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор 42.7 сая, нийт 213.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс байр ашиглахтай холбоотой тогтмол зардалд 1.4 сая, хангамж бараа материалын зардалд 15.3 сая, нормативт зардалд 21.5 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 10.0 сая, томилолт зочны зардалд 92.7 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 72.2 сая, нийт 213.1 сая төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлогыг төвлөрүүлээгүй ба Ковид-19 халдвараар өвдсөн иргэдийн тусгаарлах байр, хоолны мөнгийг хүлээн авч, аж ахуйн нэгж байгууллагад шилжүүлэн өгсөн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Онцгой байдлын газрын 2021 оны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл байхгүй байна.

3.9 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ШАЛГАСАН НИЙЦЛИЙН АУДИТЫН АСУУДАЛ

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Онцгой байдлын газар 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 109 мэдээллийг хугацаандаа оруулсан, 8 мэдээллийн хугацаа хоцроож мэдээлсэн, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгахад алдаа зөрчил илрээгүй, хугацаа хоцроосон мэдээллийг нөхөж байршуулсан ба мэдээлсэн байдлын хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Онцгой байдлын газар нь 2021 онд 1,829.9 сая төгрөгийн батлагдсан төсвөөр, төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансанд оруулбал зохих 107 мэдээллээс 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг огт байршуулаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, шилэн дансанд заавал байршуулах мэдээллийг бүрэн байршуулах талаар зөвлөмж өгөгдсөн ба зөрчлийг арилгаж, бүх мэдээллийг бүрэн байршуулсан боловч 6 мэдээллийг 1-7 хоногоор хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.9 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. **Хөрөнгө, бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал**

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 3.9 сая төгрөгийн компьютер, принтер зэрэг үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд орлогод авч бүртгэсэн зөрчил илэрлээ.

1.2. Өгсөн зөвлөмж:

Бараа материалын дансанд орлогод авсан 3.9 сая төгрөгийн компьютер, принтерийг үндсэн хөрөнгө дансанд шилжүүлэн бүртгэж, зөрчлийг арилгах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Онцгой байдлын газар	1	3.9							1	3.9